ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цэцэн-Уул сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ЗАА-2025/057/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улиастай сум

2025 он


Дарга,
тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365 Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар
Утас: 99105506 Цахим хаяг: BoldbaatarH@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Заяа
Утас: 90088028 Цахим хаяг: zayag@audit.gov.mn

Гэрээт аудитор : Ц.Алтантуул

Утас: 91195554 Цахим хаяг: tuul9565@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт 3

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 4

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 4

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан 4

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 5

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 7

3. Санхүүгийн тайлангийн тодруулга 8

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 8

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 10

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 10

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт 11

4. Аудитын тайлан 13

4.1 Ерөнхий зүйл 13

4.2 Материаллаг байдал 14

4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт 14

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 14

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 15

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал 16

5. Аудитын илрүүлэлт 16

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.02.18 № 146

танай_________________-ны №____________________ -т

ЦЭЦЭН-УУЛ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА А.БЯМБАЖАРГАЛ-Д

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Цэцэн-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тус байгууллага нь эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтээр 692.8 сая төгрөгийн, үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлогоор 189.2 сая төгрөгийн, үндсэн үйл ажиллагааны орлогоор 3.5 сая төгрөгийн нийт 885.5 сая төгрөгийн орлого бүрдүүлэн үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Цэцэн-Уул сумын Эрүүл мэндийн төв нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан тодруулгуудад дүгнэлт өгөх аудитаар 0.5 сая төгрөгийг Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин, спортын арга хэмжээнд зарцуулсан, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан орон тооноос 1 орон тоог илүү ажиллуулан 5.8 сая төгрөгийн цалин олгосон зэрэг зөрчил илэрсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд Цэцэн-Уул сумын Эрүүл мэндийн төв нь нийт 132 хүнийг эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн. Мөн осол гэмтлийн 6, халдварт өвчний 151, алсын 168, төрөлтийн 23 дуудлага бүртгэгдсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**2024 оны 12 дугаар сарын 31** **/төгрөгөөр/**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **42,932,873.67** | **75,206,051.80** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 1,005.28 | 84,442.10 |
| **312** | **Банканд байгаа бэлэн мөнгө** | 1,005.28 | 84,442.10 |
| **3121** | **Төгрөг** | 1,005.28 | 84,442.10 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 1,005.28 | 84,442.10 |
| **33** | **АВЛАГА** | 9,344,420.00 | 61,423,761.10 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 1,392,308.80 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 9,344,420.00 | 60,031,452.30 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 33,587,448.39 | 13,697,848.60 |
| **351** | **Түүхий эд материал** | 8,422,171.36 | - |
| 35130 | Эм боох материал | 8,422,171.36 | - |
| **354** | **Хангамжийн материал** | 25,165,277.03 | 13,697,848.60 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 452,900.00 | - |
| 35420 | Аж ахуйн материал | 8,160,276.00 | 2,657,232.00 |
| 35460 | Хүнсний материал | 5,534,681.80 | 6,852,800.40 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 11,017,419.23 | 4,187,816.20 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **494,877,506.69** | **606,131,917.87** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 494,877,506.69 | 606,131,917.87 |
| **392** | **Биет хөрөнгө** | 483,287,506.69 | 594,541,917.87 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 484,376,860.00 | 484,376,860.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (121,802,126.55) | (152,901,186.47) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 72,017,860.60 | 189,281,426.60 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (58,121,194.06) | (43,621,010.10) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 237,728,948.45 | 271,313,404.85 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (135,467,627.61) | (158,144,585.84) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 21,839,855.94 | 23,533,449.14 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (17,704,370.08) | (19,715,740.31) |
| 39217 | Ном | 419,300.00 | 419,300.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 11,590,000.00 | 11,590,000.00 |
| 39301 | Программ хангамж | 820,000.00 | 820,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (820,000.00) | (820,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 11,590,000.00 | 11,590,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **537,810,380.36** | **681,337,969.67** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **25,496,566.37** | **53,492,803.68** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 25,496,566.37 | 53,492,803.68 |
| **413** | **Өглөг** | 25,496,566.37 | 53,492,803.68 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 5,666,821.35 | 35,722,697.69 |

| | | | |
|---|---|---|---|
| **4136** | **Бусад өглөг** | 19,829,745.02 | 17,770,105.99 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 19,829,745.02 | 9,562,105.99 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 8,208,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **512,313,813.99** | **627,845,165.99** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 512,313,813.99 | 627,845,165.99 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 134,827,449.00 | 134,827,449.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 134,827,449.00 | 134,827,449.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 63,369,982.01 | 189,901,334.01 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 87,851,513.25 | 74,369,982.01 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (24,481,531.24) | 115,531,352.00 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 314,116,382.98 | 303,116,382.98 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **537,810,380.36** | **681,337,969.67** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **559,660,361.75** | **935,645,228.83** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **59,684,859.37** | **242,786,302.33** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 59,684,859.37 | 182,754,850.03 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 15,000,000.00 | 3,500,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 15,000,000.00 | 3,500,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 37,656,279.00 | 173,307,049.60 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 7,028,580.37 | 5,947,800.43 |
| **122** | **Тусламжийн орлого** | - | 60,031,452.30 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | - | 60,031,452.30 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **499,975,502.38** | **692,858,926.50** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 27,869,000.00 | 31,576,800.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 27,869,000.00 | 31,576,800.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 472,106,502.38 | 661,282,126.50 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | | |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 472,106,502.38 | 661,282,126.50 |
| 134003 | Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт | | |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **584,141,892.99** | **820,113,876.83** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **584,141,892.99** | **820,113,876.83** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 584,117,840.92 | 820,030,796.82 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 313,848,988.70 | 489,629,542.18 |

| | | | |
|---|---|---|---|
| 210101 | Үндсэн цалин | 220,769,044.53 | 289,244,113.76 |
| 210102 | Нэмэгдэл | 69,398,062.43 | 132,895,237.42 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,412,000.00 | 11,898,758.00 |
| 210104 | Урамшуулал | 20,269,881.74 | 55,591,433.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 48,846,100.00 | 56,274,836.04 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 33,215,000.00 | 37,077,336.04 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,907,800.00 | 4,799,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,126,200.00 | 2,399,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 781,700.00 | 2,399,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,815,400.00 | 9,598,700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 23,969,947.93 | 21,826,491.97 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,327,347.93 | 3,078,359.99 |
| 210302 | Түлш, халаалт | 21,187,600.00 | 18,493,131.98 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 455,000.00 | 255,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 28,494,160.00 | 64,553,032.23 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,603,200.00 | 4,811,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,253,100.00 | 28,300,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,026,200.00 | 1,024,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,611,660.00 | 30,417,432.23 |
| **2105** | **Нормативд зардал** | 86,584,468.38 | 107,024,955.98 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 79,259,069.58 | 98,106,174.58 |
| 210502 | Хоол, хүнс | 7,325,398.80 | 8,918,781.40 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,484,400.00 | 2,487,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,484,400.00 | 2,487,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,104,000.00 | 4,197,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,104,000.00 | 4,197,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,634,000.00 | 1,650,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 500,000.00 | 363,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,080,000.00 | 540,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 60,000.00 | 60,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 148,000.00 | 148,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 99,000.00 | 99,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 627,000.00 | - |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 120,000.00 | 440,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 70,151,775.91 | 72,387,938.42 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,800,298.00 | 1,364,300.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 60,351,477.91 | 71,023,638.42 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 24,052.07 | 83,080.01 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 24,052.07 | 83,080.01 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 24,052.07 | 83,080.01 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(24,481,531.24)** | **115,531,352.00** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(24,481,531.24)** | **115,531,352.00** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | **482,631,082.38** | **705,703,346.50** |

| | | | |
|---|---|---|---|
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **15,000,000.00** | **3,500,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 15,000,000.00 | 3,500,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 15,000,000.00 | 3,500,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 15,000,000.00 | 3,500,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **467,631,082.38** | **702,203,346.50** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 27,869,000.00 | 31,576,800.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 27,869,000.00 | 31,576,800.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 439,762,082.38 | 670,626,546.50 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | | |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 439,762,082.38 | 670,626,546.50 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **482,640,223.95** | **704,856,909.68** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **482,640,223.95** | **704,856,909.68** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **482,616,171.88** | **704,773,829.67** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 307,405,124.64 | 457,248,710.68 |
| 210101 | Үндсэн цалин | 214,325,180.47 | 256,863,282.26 |
| 210102 | Нэмэгдэл | 69,398,062.43 | 132,895,237.42 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,412,000.00 | 11,898,758.00 |
| 210104 | Урамшуулал | 20,269,881.74 | 55,591,433.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 48,846,100.00 | 59,992,100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 33,215,000.00 | 40,794,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,907,800.00 | 4,799,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,126,200.00 | 2,399,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 781,700.00 | 2,399,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,815,400.00 | 9,598,700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 24,844,947.93 | 28,493,719.99 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,202,347.93 | 3,078,359.99 |
| 210302 | Түлш, халаалт | 21,187,600.00 | 25,160,360.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 455,000.00 | 255,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 25,207,500.00 | 34,847,600.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,044,200.00 | 2,488,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,253,100.00 | 28,300,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,026,200.00 | 1,024,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 780,000.00 | 300,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,104,000.00 | 2,734,900.00 |
| **2105** | **Нормативд зардал** | 56,855,801.31 | 102,283,399.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 51,974,001.31 | 90,344,499.00 |
| 210502 | Хоол, хүнс | 4,881,800.00 | 10,438,900.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 1,500,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,670,500.00 | 7,938,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,200,000.00 | 1,183,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | 5,470,500.00 | 6,754,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,104,000.00 | 4,197,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,104,000.00 | 4,197,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,634,000.00 | 1,720,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 500,000.00 | 363,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,080,000.00 | 540,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 60,000.00 | 60,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 148,000.00 | 148,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 99,000.00 | 99,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 627,000.00 | - |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 120,000.00 | 510,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 6,048,198.00 | 8,053,300.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,048,198.00 | 8,053,300.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **24,052.07** | **83,080.01** |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 24,052.07 | 83,080.01 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 24,052.07 | 83,080.01 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **(9,141.57)** | **846,436.82** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **-** | **763,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **763,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 763,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 763,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-** | **(763,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (9,141.57) | 83,436.82 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 10,146.85 | 1,005.28 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 1,005.28 | 84,442.10 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 134,827,449.00 | 314,116,382.98 | 87,851,513.25 | 536,795,345.23 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **134,827,449.00** | **314,116,382.98** | **87,851,513.25** | 536,795,345.23 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | (24,481,531.24) | (24,481,531.24) |
| C08 | **2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **134,827,449.00** | **314,116,382.98** | **63,369,982.01** | 512,313,813.99 |
| D01 | **2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **134,827,449.00** | **314,116,382.98** | **63,369,982.01** | 512,313,813.99 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 11,000,000.00 | 11,000,000.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **134,827,449.00** | **314,116,382.98** | **74,369,982.01** | 523,313,813.99 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | (11,000,000.00) | - | (11,000,000.00) |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 115,531,352.00 | 115,531,352.00 |
| D09 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **134,827,449.00** | **303,116,382.98** | **189,901,334.01** | 627,845,165.99 |

**2.5.1 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан / үндсэн санхүүжилт /**

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 725,201,200.00 | 674,043,109.68 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 725,201,200.00 | 674,043,109.68 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 725,201,200.00 | 674,043,109.68 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 489,936,900.00 | 457,248,710.68 |
| 210101 | Үндсэн цалин | 268,992,000.00 | 256,863,282.26 |
| 210102 | Нэмэгдэл | 155,536,900.00 | 132,895,237.42 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,808,000.00 | 11,898,758.00 |
| 210104 | Урамшуулал | 59,600,000.00 | 55,591,433.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 59,992,100.00 | 59,992,100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 40,794,600.00 | 40,794,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,799,400.00 | 4,799,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,399,700.00 | 2,399,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,399,700.00 | 2,399,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,598,700.00 | 9,598,700.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 39,339,300.00 | 34,847,600.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,878,400.00 | 2,488,700.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210402 | Тээвэр, шатахуун | 29,400,300.00 | 28,300,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,585,000.00 | 1,024,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 775,600.00 | 300,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,700,000.00 | 2,734,900.00 |
| **2105** | **Нормативд зардал** | 107,936,600.00 | 102,283,399.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 95,292,100.00 | 90,344,499.00 |
| 210502 | Хоол, хүнс | 11,144,500.00 | 10,438,900.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,500,000.00 | 1,500,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 10,903,000.00 | 5,558,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,828,000.00 | 620,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,200,000.00 | 1,183,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,875,000.00 | 3,754,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,447,000.00 | 4,197,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,447,000.00 | 4,197,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,546,000.00 | 1,720,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 446,100.00 | 363,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 540,000.00 | 540,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 60,000.00 | 60,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 148,000.00 | 148,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 99,000.00 | 99,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 542,900.00 | - |
| 210807 | Газрын төлбөр | 140,000.00 | - |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 60,000.00 | - |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 510,000.00 | 510,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 10,100,300.00 | 8,196,300.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,100,300.00 | 8,196,300.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 721,690,000.00 | 670,626,546.50 |
| **122** | **ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ** | 721,690,000.00 | 670,626,546.50 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 721,690,000.00 | 670,626,546.50 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | 1,005.28 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 84,442.10 |

**2.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **31,576,800.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **31,576,800.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 31,493,719.99 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 28,493,719.99 |

| | | |
|---|---|---|
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,078,359.99 |
| 210302 | Түлш, халаалт | 25,160,360.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 255,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,000,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 83,080.01 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **83,080.01** |
| 213503 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 83,080.01 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 31,576,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 31,576,800.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 31,576,800.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

***Цэцэн-Уул сумын эрүүл мэндийн төвийн зорилго:*** Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг стандартын дагуу аюулгүй, эрсдэлгүй орчинд чанарын өндөр түвшинд, ил тод, шуурхай, хүртээмжтэй үзүүлэхийн зэрэгцээ орчин үеийн оношилгоо, эмчилгээг үйлчилгээндээ нэвтрүүлэх .

- Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 10 зорилтын хүрээнд 75 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 80 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

***Цэцэн-Уул сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд мөрддөг хууль:***

1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
2. Эрүүл мэндийн тухай хууль
3. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
4. Төсвийн тухай хууль
5. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
6. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
7. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
8. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
9. Хөдөлмөрийн тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Дотоод хяналтын багийг байгуулж, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цэцэн-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьаар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн суурьаар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Цэцэн-Уул сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 143,527.50 мянган төгрөгөөр буюу 26.7 хувиар өссөн байна.

***Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт***

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Төрийн сангийн харилцах | 1.0 | 84.4 | 83.4 |
| Авлага | 9,344.40 | 61,423.70 | 52,079.30 |
| Бараа материал | 33,587.50 | 13,697.88 | (19,889.62) |
| Үндсэн хөрөнгө | 494,877.50 | 606,131.90 | 111,254.40 |
| **Нийт хөрөнгө** | **537,810.40** | **681,337.90** | 143,527.50 |
| **Өглөг** | 25,496.6 | 53,492.8 | 27,996.2 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 512,313.80 | 627,845.20 | 115,531.40 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **537,810.40** | **681,337.90** | 143,527.50 |

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

**Тайланд онд:**

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 83.4 мянган төгрөгөөр өссөн нь зарцуулаагүй үлдэгдэлтэй холбоотой байна.

Авлагын үлдэгдэл 52,078.30 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага үүссэнтэй холбоотой байна.

Бараа материалын эхний үлдэгдэл 33,587.50 мянган төгрөг байсан бөгөөд төсвийн хөрөнгөөр 148,419.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, эрүүл мэндийн яамнаас 5,947.8 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр нэмэгдэж,174,257.1 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, эцсийн үлдэгдэл 13,697.88 мянган төгрөг болж, өмнөх оноос 19,889.62 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн хувьд төсвийн хөрөнгөөр 8,971.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хөрөнгө оруулалтаар 173,307.0 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, элэгдэл тооцсоноор жилийн эцэст 606,131.9 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 71,023.6 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Богино хугацаат өр төлбөрийн дүн өмнөх оноос 27,996.10 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 115,531.40 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 725,201.2 мянган төгрөг, нийт зарлагыг 725,201.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр эрүүл мэндийн даатгалын сангаас 670,626.5 мянган төгрөг, өөрийн орлогоос 3,500.0 мянган төгрөг, нийт 674,126.5 мянган төгрөгийн орлого төврүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 674,043.0 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байна.

***Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл***

*/мянган төгрөгөөр/*

| Хөтөлбөр арга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | | | | | |
| 80302 | Нэг иргэнд ногдох нормативаар | 551,781.6 | 551,698.1 | 83.4 | 99.9% |
| 81603 | үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ | 122,344.9 | 122,344.9 | 0 | 100% |
| **НИЙТ** | | **674,126.5** | **674,043.0** | **83.4** | **99.9%** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 31,576.8 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж тогтмол зардалд 28,493.7 мянган төгрөгийг урсгал засварт 3,000.0 мянган төгрөгийг зарцуулж 83.1 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

*/мянган төгрөг/*

| № | Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга | Бараа ажил үйлчилгээний нэр | Төлөвлөлт | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|
| 1 | Шууд гэрээ байгуулах | Хөрөнгө оруулалтын хөрөнгийн зардал | 763.0 | 763.0 |
| 2 | Шууд гэрээ байгуулах | Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 93,320.4 | 88,438.0 |
| 3 | Шууд гэрээ байгуулах | Хэвтэн эмчлүүлэгчийн хоолны зардал | 10,602.0 | 9,957.5 |
| **ДҮН** | | | **104,685.40** | **99,158.50** |

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

## 4.АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Цэцэн-Уул сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн

байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүлд аудит ХХК-ийн гэрээт аудитор Ц.Алтантуул гүйцэтгэж хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Заяа , аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Цэцэн-Уул сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 17 -ны өдөр 06 дугаартай албан тоотоор ирүүлсэн байна.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 820,113.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 12,301.7 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзсэн.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан.**

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Цэцэн-Уул сумын эрүүл мэндийн төвийн шилэн дансны мэдээллийг шалгахад алдаа, зөрчил илрээгүй.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай *нийцсэн байна* гэж дүгнэлээ.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Цэцэн-Уул сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2,653.2 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 2 | 2,653.2 | 2 | 2,653.2 | 100% |
| **Нийт дүн** | **2** | **2,653.2** | **2** | **2,653.2** | **100%** |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 5,850.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлэн албан шаардлага хүргүүлсэн.

**5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй.**

**5.2 Албан шаардлага**

Батлагдсан бүтэц орон тооноос илүү ажилтан ажиллуулан 5,850.0 мянган төгрөгийн цалингийн үрэлгэн зардал гаргасан зөрчлийг таслан зогсоох албан шаардлагыг хүргүүллээ.

**5.3 Зөвлөмж хүргүүлээгүй**

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

*/мянган төгрөгөөр/*

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруу-лаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Батлагдсан бүтэц орон тооноос илүү ажилтан ажиллуулсан | 1 | 5,850.0 | | | 1 | 5,850.0 | | | | | | |
| Дүн | 1 | 5,850.0 | | | 1 | 5,850.0 | | | | | | |

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

ХЯНАСАН:

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

АУДИТЫН МЕНЕЖЕР Х.БОЛДБААТАР

АХЛАХ АУДИТОР Г.ЗАЯА

БОЛОВСРУУЛСАН:

СҮЛД АУДИТ ХХК-ИЙН

ГЭРЭЭТ АУДИТОР Ц.АЛТАНТУУЛ ОГНОО: 2025-02-22